

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР 2019 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ
ТОЙМ ДҮГНЭЛТ**

Боловсруулсан:
Д. Баярмаа (ШУТИС-БуХС-ийн багш, докторант)

Хянан тохиолдуулсан: Д. Оюунбадам

2018 оны 11-р сар

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	1
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2019 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОЙМ.....	2
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2019 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ.....	4
ГУРАВ. ОЙРОЛЦОО ХҮЧИН ЧАДАЛТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ	9
ДӨРӨВ. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН 2019 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН.....	10
ТАВ.ТОЙМ ДҮГНЭЛТ.....	12

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БСШУС	–	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
ЗДТГ	–	Засаг даргын тамгын газар
ЗГ	–	Засгийн газар
МУ	–	Монгол Улс
ННФ	–	Нээлттэй нийгэм форум
ТЕЗ	–	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	–	Техник эдийн засгийн үндэслэл
УБ	–	Улаанбаатар
УИХ	–	Улсын их хурал
ҮАГ	–	Үндэсний Аудитын Газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	2019 онд шинээр эхлэх төсөвт өртөг өндөртэй их засварын ажлууд (сая төгрөг)	7
Хүснэгт 2.	2019 онд шинээр худалдан авах төсөвт өртөг өндөртэй тоног төхөөрөмжүүд (сая төгрөг)	8
Хүснэгт 3.	2019 онд шинээр хэрэгжүүлж эхлэх ойролцоо хүчин чадалтай барилга байгууламжуудын төсөвт өртөг (сая төгрөг)	9
Хүснэгт 4.	Нийт төсөвт өртөгт 2019 оны санхүүжилтийн дүнгийн эзлэх хувийн жин хамгийн багатай төсөл, арга хэмжээнүүд (сая төгрөг)	11

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт	2
Зураг 2.	2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дуусах огноо	3
Зураг 3.	2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт/ Төсвийн ерөнхийлөн захирагчаар/	4
Зураг 4.	2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт /үндсэн ангилаар/	4
Зураг 5.	2019 онд шинээр эхлэх барилга байгууламж	5
Зураг 6.	2019 онд шинээр эхлэх их засвар	6
Зураг 7.	2019 онд шинээр эхлэх их засвар /салбараар/	6
Зураг 8.	2019 онд шинээр худалдан авах тоног төхөөрөмж	7
Зураг 9.	2019 онд шинээр худалдан авах тоног төхөөрөмж /зориулалтаар/	8
Зураг 10.	Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2019 онд санхүүжих дүн	10

ХУРААНГУЙ

Нээлттэй Нийгэм Форумгаас жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тойм шинжилгээ хийж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, хэвлэл мэдээллийнхэн, иргэд, олон нийтэд танилцуулдаг. Тайлангийн үндсэн зорилго нь төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий байдлаар богино хугацаанд танилцуулж, хараат бус, хөндлөнгийн дүгнэлт өгөхөд оршино.

Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хийсэн тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтаж байна. Үүнд:

- 2019 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тойм мэдээлэл
- 2019 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төрөл, ангилал
- Ойролцоо хүчин чадалтай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртгийн талаарх мэдээлэл
- 2019 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжуудын 2019 оны санхүүжилтийн хэмжээ

Энэхүү танилцуулгыг боловсруулахдаа Засгийн газраас 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Монгол Улсын 2019 оны төсвийн төслийн баримт бичиг, Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд болон холбогдох бусад төрийн байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлав.


Энэхүү танилцуулга нь Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурь биш бөгөөд гагцхүү хувь судлаачийн байр суурийг илтгэнэ.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2019 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОЙМ

2019 онд 1297.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 515 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг шинээр эхлүүлнэ.

Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 21 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2546.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 877 төсөл, арга хэмжээг 1217.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс нийт 1297.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 515 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 2019 онд шинээр эхлүүлэх ба нийт 1249.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 362 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж өмнөх оноос шилжиж ирнэ.

Зураг 1. 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтыг Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зарим зорилтуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх бодлого баримтлахаар төлөвлөжээ. Үүнд: Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлэх; Анхан шатлалын эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар, хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулах; Гаалийн иж бүрэн бүртгэл, хяналтын тогтолцоо, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтуудыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлнэ.

Шинээр эхлэх 279 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж 2019 онд багтаж дуусах ба бусад нь он дамжина.

Шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нийт төсөвт өртгийн 32.3 хувь буюу 419.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 279 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж 2019 онд багтаж дуусах ба бусад нь он дамжина. Тухайлбал, 2020 онд 832.9 тэрбум төгрөгийг төсөвт өртөгтэй 232 төсөл, арга

хэмжээ, барилга байгууламж, 2021 онд 26.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, 2022 онд 18.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэж дуусгахаар төлөвлөсөн.

Зураг 2. 2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дуусах огноо



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Үндэсний Аудитын Газраас 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийн 71.3 хувь нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь баталгаажсаагүй байна гэж дүгнэжээ.

Үндэсний Аудитын Газар (ҮАГ)-аас “Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт”-д “Монгол Улсын 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 515 төсөл, арга хэмжээнээс 71.3 хувь нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь магадлалаар баталгаажсаагүй, мөн 2018 оны 10 дугаар сарын байдлаар гэрээ байгуулагдаж, ажил эхлээгүй хөрөнгө оруулалтын шилжих нийт 54 төсөлд 75.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн зэргээс харахад 2019 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хугацаа алдах эрсдэлтэй байна. Түүнчлэн 2019 оны төсвийн төсөлд гэрэлтүүлэг, зам, талбайн тохижилт, мал угаах онгоц, ногооны зоорь зэрэг нийслэл, орон нутгийн төсөв, урсгал зардлаар санхүүжүүлэх боломжтой нийт 32 төсөлд 21.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ... Монгол Улсын 2019 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын ихэнх төсөл, хөтөлбөрүүд нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт заасны дагуу нийгэм, эдийн засгийн ач холбогдлоороо эрэмбэлэгдээгүй, улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, салбарын хөгжлийн бодлоготой уялдаагүйгээс 2018 оны Төсвийн хүрээний мэдэгдлээс давсан, төсвийн хязгаарыг баримтлаагүй, шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөх хуулийн шаардлага хангаагүй байна... Улсын


төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээг төлөвлөх, түүний эх үүсвэрийг давхардуулах эрсдэл байна” гэж дүгнэжээ.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2019 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

2019 онд шинээр хэрэгжүүлж эхлэх хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарт ногдоно.

2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) нар-ын эзлэх хувийн жингээр нь эрэмбэлэн авч үзвэл, БСШУС-ын сайд 30.7%, Зам тээврийн хөгжлийн сайд 24.5%, Сангийн сайд 12.9%, Эрчим хүчний сайд 6.4%, Барилга, хот байгуулалтын сайд 6.3%, Эрүүл мэндийн сайд 5.5%, бусад сайд нарт 13.9% ноогдож байна.


Зураг 3. 2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт/ТЕЗ-аар/



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтыг үндсэн ангилалаар нь авч үзвэл барилга байгууламж 85.3%, их засвар 6.5%, тоног төхөөрөмж 17.9%, ТЭЗҮ 0.3%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 4. 2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалт /үндсэн ангиллаар/




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2019 онд нийт 1106.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 395 барилга байгууламжийг шинээр эхлүүлнэ.

2019 онд нийт 1106.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 395 барилга байгууламжийг шинээр эхлүүлнэ. Үүнд 2.5 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 105 барилга байгууламж, 0.9-2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 195 барилга байгууламж, 0.9 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй 95 барилга байгууламж байна. Нийт төсөвт өртгийн 52 хувь буюу 576.3 тэрбум төгрөгийг 2019 онд санхүүжүүлнэ.

Зураг 5. 2019 онд шинээр эхлэх барилга байгууламж



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


2019 онд шинээр эхлэх барилга байгууламжуудыг төрөл, тоогоор нь авч үзвэл цэцэрлэгийн ба цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 59, бага сургууль ба сургуулийн барилга 36, дотуур байрны барилга 20, ЗДТГ-ын барилга 14, соёлын төвийн барилга 12, эрүүл мэндийн төвийн барилга 12, сургуулийн спорт заалын барилга 9, аймгийн төвийн хатуу хучилттай зам 7, соёл, спортын төв, цогцолборын барилга 6, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга 6, багийн төвийн барилга 6, цагдаагийн хэлтсийн барилга 4, гаалийн шинэчлэл 3, нэгдсэн эмнэлгийн барилга 2, хүүхдийн эмнэлгийн 2 гэх мэт төлөвлөгджээ. Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид бүрэн шилжүүлэх ЗГ-ын бодлогыг үргэлжлүүлэх зорилгоор олон сургууль, цэцэрлэгийн барилгыг төлөвлөсөн нь сайшаалтай боловч ЗДТГ-ын барилга, соёлын төвийн барилга гэх мэт тэвчиж болох барилга, байгууламжуудыг олноор төлөвлөжээ.

2019 онд нийт 84.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 75 их засварын ажлыг шинээр эхлүүлнэ.

2019 онд нийт 849 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 75 их засварын ажлыг шинээр эхлүүлнэ. Үүнд 0.9 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 19 их засвар, 0.15-0.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 37 их засвар, 0.15 тэрбум төгрөгөөс доош төсөвт

өртөгтэй 19 их засварын ажил байна. Нийт төсөвт өртгийн 93 хувь буюу 79 тэрбум төгрөгийг 2019 онд санхүүжүүлнэ.


Зураг 6. 2019 онд шинээр эхлэх их засвар



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2019 онд шинээр эхлүүлэх их засварын ажлын төсөвт өртгийн дийлэнх хувь буюу 64.2 хувь нь зам тээврийн салбарт зарцуулагдах ба Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбарт 13.2 хувь, барилга хот байгуулалтад 5.6 хувь, засгийн газар, төрийн ордон, элчин сайдын яамдуудад 4.3 хувь, эрүүл мэндийн салбарт 4.1 хувь, гаалийн шинэчлэлд 2.7 хувь, хөдөлмөр, нийгмийн хамгаалалд 2.4 хувь, улсын дээд шүүхэд 2.4 хувь, эрчим хүчний салбарт 0.8 хувь, цагдаагийн газарт 0.3 хувь тус тус ногдоно.

Зураг 7. 2019 онд шинээр эхлэх их засвар /салбараар/



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Хүснэгт 1. 2019 онд шинээр эхлэх төсөвт өртөг өндөртэй их засварын ажлууд (сая төгрөг)

	Их засвар	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалт /улсын хэмжээнд/	30,000.0	30,000.0
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/	10,000.0	5,000.0
3	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /улсын хэмжээнд/	3,000.0	3,000.0
4	Хороодын доторх авто замын засвар, тохижилт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 6, 15, 18, 25 дугаар хороо/	2,500.0	2,500.0
5	Гаалийн шинэчлэл - Гаалийн газар, хороодын барилгын их засвар /улсын хэмжээнд/	2,320.0	2,320.0
6	Зэвсэгт хүчний барилга, байгууламжийн их засвар /улсын хэмжээнд/	2,000.0	2,000.0
7	Хороолол доторх авто замын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо/	2,000.0	2,000.0
8	Хороолол доторх авто замын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 7 дугаар хороо/	2,000.0	2,000.0
9	Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/	2,000.0	2,000.0
10	Улсын дээд шүүхийн байруудын их засвар /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2,000.0	2,000.0


Эх сурвалж: Сангийн яам

2019 онд нийт 102.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 42 тоног төхөөрөмж шинээр худалдан авна.

2019 онд нийт 102.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 42 тоног төхөөрөмж шинээр худалдан авна. Үүнд 1.4 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй 11 тоног төхөөрөмж, 0.25-1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй 19 тоног төхөөрөмж, 0.25 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй 12 тоног төхөөрөмж байна. Нийт төсөвт өртгийн 91.2 хувь буюу 93.5 тэрбум төгрөгийг 2019 онд санхүүжүүлнэ.

Зураг 8. 2019 онд шинээр худалдан авах тоног төхөөрөмж

Төсөвт өртөг тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2019 онд нийт шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн 48 хувь нь гаалийн шинэчлэлд, 9.8 хувь нь үндэсний дата төвд, 9.7 хувь нь батлан хамгаалах, 7.7 хувь нь боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбарт, 5.8 хувь нь эрүүл мэндийн салбарт, 5.3 хувь нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт, 2.7 хувь нь хил хамгаалахад, 2 хувь нь улсын дээд шүүхэд, 9 хувь нь бусад үйл ажиллагаанд зориулагдана.

Зураг 8. 2019 онд шинээр худалдан авах тоног төхөөрөмж /зориулалтаар/



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Хүснэгт 2. 2019 онд шинээр худалдан авах төсөвт өртөг өндөртэй тоног төхөөрөмжүүд (сая төгрөг)

	Их засвар	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Гаалийн шинэчлэл - Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	32,195.2	32,195.2
2	Гаалийн шинэчлэл - Гаалийн ерөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	17,000.0	17,000.0
3	Үндэсний дата төвийн албан хэрэгцээний тоног төхөөрөмж, шинэчлэлт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	10,000.0	4,000.0
4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	7,000.0	7,000.0
5	Радиолокацийн станцийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	6,250.0	3,250.0
6	Жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	4,000.0	4,000.0
7	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	4,000.0	4,000.0
8	Зэвсэгт хүчний албан хэрэгцээнд нисдэг тэрэг худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	3,696.0	3,696.0
9	Улсын дээд шүүхийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2,000.0	2,000.0
10	Хил хамгаалах салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	1,700.0	1,700.0

Эх сурвалж: Сангийн яам

**ГУРАВ. ОЙРОЛЦОО ХҮЧИН ЧАДАЛТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВТ ӨРТӨГ**

Ойролцоо хүчин чадалтай барилга байгууламжуудын төсөвт өртөг хэлбэлзэл өндөртэй байна.

2017 онд шинээр хэрэгжүүлж эхлүүлэх ойролцоо хүчин чадалтай барилга байгууламжуудыг түүвэрлэн авч төсөвт өртгүүдийг харьцуулан авч үзвэл хэлбэлзэл өндөр байна. Тухайлбал, багийн төвийн барилгуудын төсөвт өртөг 40-350 сая төгрөг, ЗДТГ-ын барилгуудын төсөвт өртөг 0.8-1.3 тэрбум төгрөг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгуудын төсөвт өртөг 0.47-6.9 тэрбум төгрөг, Цагдаагийн хэлтсийн барилгуудын төсөвт өртөг 1.1-3 тэрбум төгрөг, Цэцэрлэгийн барилгын төсөвт өртөг 0.45-3.2 тэрбум төгрөг, Сургуулийн барилгын төсөвт өртөг 1.1-8.7 тэрбум төгрөг, Соёлын төвийн барилгуудын төсөвт өртөг 1.1-3.5 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хувьд хүүхдийн тоо, ор, суудал зэргээс хамааран төсөвт өртөг нь ялгаатай байж болох ч бусад барилга байгууламжуудын хувьд төсөвт өртгийн хэлбэлзэл өндөр байгааг дахин хянах шаардлагатай.

Хүснэгт 3. 2019 онд шинээр хэрэгжүүлж эхлэх ойролцоо хүчин чадалтай барилга байгууламжуудын төсөвт өртөг (сая төгрөг)

	Тоо	Төсөвт өртөг (Хэлбэлзэл)	Дундаж өртөг	Санхүүжилт (Хэлбэлзэл)	Дундаж санхүүжилт
Багийн төвийн барилга	6	40-350	145.8	40-350	145.8
Засаг даргын тамгын газрын барилга	14	825.1-1300	1087.9	500-860.8	624.0
Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга	6	470-6937.1	1842.9	300-2000	720.0
Цагдаагийн хэлтсийн барилга	4	1135.3-3000	2078.4	1000-2100	1411.8
Бага сургуулийн барилга	3	1151-2155.6	1677.7	1000-1726.6	1292.5
Дотуур байрны барилга	20	900-2298.9	1397.6	500-1500	830.0
Сургуулийн барилга	32	1100-8700	4014.8	400-3300	1651.9
Сургуулийн спорт заалын барилга	9	653.3-1200	965.0	500-1200	853.9
Цэцэрлэгийн барилга	46	450-3200	1489.1	400-2500	1082.9
Соёлын төвийн барилга	22	1100-3500	1499.4	455-2800	951.7
Эрүүл мэндийн төвийн барилга	12	250-1800	1138.0	250-900	579.2
Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга	9	250-1300	648.9	250-1000	461.3
Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам	7	2000-10200	4970.6	1000-5000	2597.4

Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

ДӨРӨВ. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН 2019 ОНЫ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН

Зарим төсөвт өртөг өндөртэй төслүүдийн 2019 онд санхүүжих дүн бага байна.

2019 онд улсын төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлж эхлэх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 57.9 хувь буюу 752.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ. 515 төсөл, арга хэмжээний 279 нь 2019 онд бүрэн санхүүжих бөгөөд эдгээрийн дийлэнх нь төсөвт өртгийн хувьд харьцангуй багатай төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд байна. Бусад төсөл, арга хэмжээ барилга байгууламжийн хувьд нийт төсөвт өртгийн 6.5-85.6 хувийг 2019 онд санхүүжүүлнэ.

Зураг 9. Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2019 онд санхүүжих дүн

Нийт төсөвт өртгөөс 2019 онд санхүүжих хувь



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Зарим төсөвт өртөг өндөртэй төсөл, арга хэмжээний 2019 онд санхүүжих дүн бага байна. Тухайлбал нийт 15.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нарны хорооллын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн барилгыг тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах төслийн зөвхөн 6.5 хувь буюу 1 тэрбум төгрөгийг 2019 онд санхүүжүүлэхээр байна. Мөн нийт 10.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн системийн төслийн 9.3 хувь, нийт 49.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто зам төслийн 10.1 хувь, нийт 48 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам төслийн 10.4 хувь, нийт 18.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хууль сахиулахын их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилга төслийн 13 хувь нь 2019 онд санхүүжихээр байна.

Хүснэгт 4. Нийт төсөвт өртөгт 2019 оны санхүүжилтийн дүнгийн эзлэх хувийн жин хамгийн багатай төсөл, арга хэмжээнүүд (сая төгрөг)

	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2019 онд санхүүжих дүн	2019 онд санхүүжих хувь	Хэрэгжиж дуусах он
1	960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Нарны хороолол/	15405.87	1000	6.5	2020
2	Замын-Үүд чөлөөт бүсийн дохиолол, хамгаалалтын нэгдсэн систем /Дорноговь, Замын-Үүд сум/	10751.68	1000	9.3	2021
3	Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 50 км /Хэнтий, Бор-Өндөр сум/	49368.2	5000	10.1	2020
4	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км /Төв, Мөнгөнморьт сум/	48000	5000	10.4	2020
5	Хууль сахиулахын их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	18500	2400	13.0	2022
6	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	3432.9	500	14.6	2020
7	Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/	6000	1000	16.7	2020
8	Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/	5500	1000	18.2	2020
9	Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхагийн байр /Улаанбаатар/	5200	1000	19.2	2020
10	Усан бассейн, спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	9,000.0	2,000.0	22.2	2021
11	Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх авто замтай холбох хатуу хучилттай авто зам /Сэлэнгэ, Мандал сум/	22,119.4	5,000.0	22.6	2020
12	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Дархан-Уул, Дархан сум, 6, 7 дугаар баг/	8,713.2	2,000.0	23.0	2020
13	Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл /Ховд, Үенч сум/	21,183.6	5,000.0	23.6	2020
14	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	2,000.0	500.0	25.0	2020
15	Сургуулийн барилга, 960 суудал /Хөвсгөл, Тариалан сум/	4,000.0	1,000.0	25.0	2020

Эх сурвалж: Сангийн яам

ТАВ. ТОЙМ ДҮГНЭЛТ

Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2019 онд шинээр хэрэгжүүлж эхлэх хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хийсэн тойм судалгааны дүнг хураангуйлан дүгнэвэл:

- Улсын төсвийн санхүүжилтээр нийт 515 төсөл, арга хэмжээ 2019 онд шинээр хэрэгжиж эхэлнэ.
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нийт төсөвт өртгийн гуравны нэг буюу 279 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж 2019 онд багтаж дуусах ба бусад нь он дамжина.
- ҮАГ-ын дүгнэлтээр 2019 онд шинээр эхлэх төсөл, арга хэмжээний 71.3 нь техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь баталгаажаагүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын бус зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарт ногдоно.
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн дийлэнх хувийг барилга байгууламж эзэлнэ.
- Ойролцоо хүчин чадалтай барилга байгууламжуудын төсөвт өртөг хэлбэлзэл өндөртэй байна.
- Шинээр эхлэх их засварын ажлын дийлэнх хувь нь зам тээврийн салбарт хийгдэнэ.
- Шинээр худалдан авах тоног төхөөрөмжийн дийлэнх хувь гаалийн шинэчлэлд зориулагдана.
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын нийт төсөвт өртгийн 57.9 хувийг 2019 онд санхүүжүүлнэ.
- Зарим төсөвт өртөг өндөртэй төслүүдийн 2019 онд санхүүжих дүн бага байна.

Засгийн газраас шинээр эхэлж буй төслүүдийн нийт төсөвт өртгийн маш бага хэсгийг эхний жилд санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь он дамжсан, дуусдаггүй барилга байгууламжууд бий болох эрсдэл үүсгэж байгаа тул эдгээр төслүүдийг 2019 онд эхлүүлэхээ зогсоох, эсхүл 2019 онд хийх санхүүжилтийн хэмжээг нэмэх шаардлагатай юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын 2019 оны төсвийн төслийн баримт бичгүүд (төсвийн хуулийн төслүүд, төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга)
2. Засгийн газраас 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
3. Үндэсний Аудитын Газар (2018). *Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт*
4. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
5. Бусад